

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум 2025 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-13
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	14-18
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. Аудитын тайлан	19-21
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. Аудитын илрүүлэлт	22-23
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	24-25

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Э.ГАНЦЭЦЭГ ТАНАА

2025.02.14 № ЦА-2025/164/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус шүүхийн Тамгын газраас Сэлэнгэ аймгийн ИТХ болон Засаг дарга нар нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын 5-д зааснаар орон нутагт ажилласны нэмэгдэл олгохгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоолгохоор нэхэмжлэл гаргаж, 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн “Эвлэрлийн гэрээ” байгуулсан байна.

Сэлэнгэ аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 159/ШШ2024/0059 дугаартай “Нэхэмжлэгч, хариуцагч нарын эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” шийдвэрийг үндэслэн тус шүүхийн төрийн захиргааны 18 албан хаагчид орон нутгийн нэмэгдэл 112,156.6 мянган төгрөгийг тооцож олгосон байна.

432502014

Аудитын гол асуудал

ШЕЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай” тогтоолд шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, докторын зэргийн нэмэгдлийг оролцуулан сарын дундаж цалин хөлснөөс тооцож, 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрөөс олгохоор тогтоосон байна.

Үүний дагуу 2023 онд өндөр насны тэтгэвэрт гарсан 1 шүүгчид зөрүү 54,204.0 мянган төгрөгийн тэтгэмжийг тайлант оны төсвөөс тооцож олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь тайлант онд “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ” зорилго дэвшүүлж, 5 зорилт, 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.3 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,137,342.00	158,271,436.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	14,040,000.00	131,490,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	14,040,000.00	131,490,000.00
3121	Төгрөг	14,040,000.00	131,490,000.00
31211	Төрийн сангийн харилцах	14,040,000.00	131,490,000.00
33	АВЛАГА	-	932,449.68
335	Бусад авлага	-	932,449.68
3351	Байгууллагаас авах авлага	-	932,449.68
35	БАРАА МАТЕРИАЛ	20,097,342.00	25,848,987.00
354	Хангамжийн материал	20,097,342.00	25,848,987.00
35410	Бичиг хэргийн материал	-	855,000.00
35420	Аж ахуйн материал	16,872,427.00	20,882,577.00
35430	Сэлбэг хэрэгсэл	760,000.00	2,600,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,464,915.00	1,511,410.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,120,096,140.37	1,174,458,593.60
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,120,096,140.37	1,174,458,593.60
392	Биет хөрөнгө	1,076,972,446.15	1,131,340,193.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,049,878,122.01	1,049,878,122.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(158,693,750.55)	(192,058,042.47)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	77,000,000.00	77,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(27,472,222.19)	(45,305,555.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	189,326,002.92	234,277,729.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,337,883.82)	(69,613,363.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,077,358.60	76,989,404.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(70,428,434.12)	(10,296,949.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,227,164.70	14,986,164.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,253,771.40)	(5,167,175.68)
39217	Ном	649,860.00	649,860.00
393	Биет бус хөрөнгө	43,123,694.22	43,118,400.00
39301	Програм хангамж	1,245,411.80	1,245,411.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,240,117.58)	(1,245,411.80)
39303	Бусад биет бус хөрөнгө	43,118,400.00	43,118,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,154,233,482.37	1,332,730,030.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	130,000,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	130,000,000.00
413	Өглөг	-	130,000,000.00
4136	Бусад өглөг	-	130,000,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	130,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,154,233,482.37	1,202,730,030.28
51	Засгийн газрын хувь оролцоо	1,154,233,482.37	1,202,730,030.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	363,793,993.87	363,793,993.87
51101	Өмч: - төрийн	363,793,993.87	363,793,993.87
512	Хуримтлагдсан үр дүн	198,076,451.80	246,572,999.71
51210	Өмнөх үеийн үр дүн	216,427,966.94	198,076,451.80
51220	Тайлант үеийн үр дүн	(18,351,515.14)	48,496,547.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	592,363,036.70	592,363,036.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,154,233,482.37	1,332,730,030.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,973,018,857.00	3,149,668,870.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,319,580.00	117,528,133.68
120	Нийтлэг татварын бус орлого	53,319,580.00	117,528,133.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,319,580.00	117,528,133.68
120009	Бусад орлого	43,647,400.00	62,828,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,727,480.00	52,005,933.68
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,944,700.00	2,694,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,919,699,277.00	3,032,140,736.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,919,699,277.00	2,907,324,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,919,699,277.00	2,907,324,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	124,816,136.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	124,816,136.40
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,991,370,372.14	3,100,597,487.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,991,370,372.14	3,100,597,487.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,872,152,592.82	2,672,287,592.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,445,954,998.61	2,075,435,601.00
210101	Үндсэн цалин	889,526,419.76	1,190,781,495.00
210102	Нэмэгдэл	379,062,344.00	616,767,750.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,451,360.00	130,150,512.00
210104	Урамшуулал	137,914,874.85	137,735,844.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,081,100.00	261,290,250.23
210201	Тэтгэврийн даатгал	125,072,780.51	178,702,727.54
210202	Тэтгэмжийн даатгал	14,119,946.61	21,134,054.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,031,957.30	11,031,064.77
210204	Ажилгүйдлийн даатгал	2,714,219.58	10,084,481.18
210205	Эрүүл мэндийн даатгал	27,142,196.00	40,337,922.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,544,120.34	67,523,639.30
210301	Гэрэл, цахилгаан	46,207,828.34	49,390,157.30
210302	Түлш, халаалт	5,540,000.00	7,612,950.00
210303	Цэвэр, бохир ус	8,796,292.00	10,520,532.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,437,772.73	82,812,370.79
210401	Бичиг хэрэг	17,158,965.00	34,589,100.00
210402	Тээвэр, шатахуун	14,017,602.00	17,501,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,267,755.73	17,734,370.79
210404	Ном, хэвлэл	-	546,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,618,450.00	12,201,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,239,600.00	48,174,320.00
210604	Урсгал засвар	11,239,600.00	48,174,320.00
2107	Томилолт, зочны зардал	14,349,600.00	19,649,700.00
210702	Дотоод албан томилолт	14,349,600.00	19,649,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,387,628.00	19,505,366.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,596,821.00	17,875,295.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,568,600.00	1,380,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,220.00	143,420.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	18,987.00	40,476.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,157,773.14	97,896,345.49
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,157,773.14	97,896,345.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,217,779.32	428,309,894.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,968,677.00	266,995,309.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	101,168,677.00	160,285,653.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	92,159,656.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	14,550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,249,102.32	161,314,584.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,249,102.32	161,314,584.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(18,351,515.14)	49,071,382.87
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	574,834.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	574,834.96
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(574,834.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(18,351,515.14)	48,496,547.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,933,699,277.00	3,162,140,736.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,000,000.00	130,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	14,000,000.00	130,000,000.00
120009	Бусад орлого	14,000,000.00	130,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,919,699,277.00	3,032,140,736.40
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,919,699,277.00	2,907,324,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,919,699,277.00	2,907,324,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	124,816,136.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	124,816,136.40
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,907,703,072.00	3,006,691,036.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,907,703,072.00	3,006,691,036.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,788,485,292.68	2,578,381,142.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,459,954,998.61	2,075,435,601.00
210101	Үндсэн цалин	903,526,419.76	1,190,781,495.00
210102	Нэмэгдэл	379,062,344.00	616,767,750.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,451,360.00	130,150,512.00
210104	Урамшуулал	137,914,874.85	137,735,844.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,081,100.00	262,222,699.91
210201	Тэтгэврийн даатгал	125,072,780.51	179,635,177.22
210202	Тэтгэмжийн даатгал	14,119,946.61	21,134,054.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,031,957.30	11,031,064.77
210204	Ажилгүйдлийн даатгал	2,714,219.58	10,084,481.18
210205	Эрүүл мэндийн даатгал	27,142,196.00	40,337,922.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,504,120.34	69,135,689.30
210301	Гэрэл, цахилгаан	46,207,828.34	49,390,157.30
210302	Түлш, халаалт	5,500,000.00	9,225,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,796,292.00	10,520,532.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,400,245.73	81,967,765.79
210401	Бичиг хэрэг	16,175,890.00	34,752,100.00
210402	Тээвэр, шатахуун	13,800,000.00	14,935,845.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,267,755.73	17,734,370.79
210404	Ном, хэвлэл	1,176,000.00	2,184,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	378,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,605,600.00	11,983,450.00
2105	Нормативт зардал	158,000.00	510,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	158,000.00	510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,999,600.00	49,954,320.00
210604	Урсгал засвар	11,999,600.00	49,954,320.00
2107	Томилолт, зочны зардал	14,349,600.00	19,649,700.00
210702	Дотоод албан томилолт	14,349,600.00	19,649,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,387,628.00	19,505,366.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,596,821.00	17,875,295.00

210803	Даатгалын үйлчилгээ	1,568,600.00	1,380,175.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,220.00	143,420.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
210807	Газрын төлбөр	18,987.00	40,476.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	650,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	650,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119,217,779.32	428,309,894.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	102,968,677.00	266,995,309.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	101,168,677.00	160,285,653.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	92,159,656.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,800,000.00	14,550,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,249,102.32	161,314,584.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,249,102.32	161,314,584.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	25,996,205.00	155,449,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,996,205.00	37,999,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,996,205.00	37,999,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,996,205.00	37,999,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,996,205.00	37,999,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,996,205.00)	(37,999,700.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	14,000,000.00	117,450,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,000.00	14,040,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,040,000.00	131,490,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	216,427,966.94	-	1,172,584,997.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	216,427,966.94	-	1,172,584,997.51
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(18,351,515.14)	-	(18,351,515.14)
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	198,076,451.80	-	1,154,233,482.37
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	198,076,451.80	-	1,154,233,482.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	198,076,451.80	-	1,154,233,482.37
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	48,496,547.91	-	48,496,547.91
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,793,993.87	592,363,036.70	246,572,999.71	-	1,202,730,030.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
	ХӨТӨЛБӨР 70701	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80101	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,632,377,800.00	2,491,158,463.34	141,219,336.66	94.64
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,632,377,800.00	2,491,158,463.34	141,219,336.66	94.64
210	Бараа, үйлчилгээний зардал	2,632,377,800.00	2,491,158,463.34	141,219,336.66	94.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,102,305,400.00	1,975,743,591.00	126,561,809.00	93.98
210101	Үндсэн цалин	1,273,732,400.00	1,190,781,495.00	82,950,905.00	93.49
210102	Нэмэгдэл	606,558,300.00	517,075,740.00	89,482,560.00	85.25
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	150,414,000.00	130,150,512.00	20,263,488.00	86.53
210104	Урамшуулал	71,600,700.00	137,735,844.00	(66,135,144.00)	192.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	262,788,200.00	249,761,199.25	13,027,000.75	95.04
210201	Тэтгэврийн даатгал	179,696,000.00	171,161,356.29	8,534,643.71	95.25
210202	Тэтгэмжийн даатгал	20,773,100.00	20,137,135.49	635,964.51	96.94
210203	ҮОМШӨ ний даатгал	10,386,500.00	10,532,604.72	(146,104.72)	101.41
210204	Ажилгүйдлийн даатгал	10,386,500.00	9,586,021.13	800,478.87	92.29
210205	Эрүүл мэндийн даатгал	41,546,100.00	38,344,081.62	3,202,018.38	92.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,224,000.00	69,135,689.30	1,088,310.70	98.45
210301	Гэрэл цахилгаан	55,504,000.00	49,390,157.30	6,113,842.70	88.98
210302	Түлш, халаалт	4,200,000.00	9,225,000.00	(5,025,000.00)	219.64
210303	Цэвэр, бохир ус	10,520,000.00	10,520,532.00	(532.00)	100.01
2104	Хангамж, бараа материалын зардал	70,591,500.00	70,508,220.79	83,279.21	99.88
210401	Бичиг хэрэг	26,000,000.00	25,820,900.00	179,100.00	99.31
210402	Тээвэр (шатахуун)	14,407,500.00	14,407,500.00	-	100.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	17,500,000.00	17,734,370.79	(234,370.79)	101.34
210404	Ном, хэвлэл	2,184,000.00	2,184,000.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	378,000.00	122,000.00	75.60
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	10,000,000.00	9,983,450.00	16,550.00	99.83
2105	Нормативт зардал	658,000.00	510,000.00	148,000.00	77.51
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	658,000.00	510,000.00	148,000.00	77.51
2106	Эд хогшил худалдан авах	88,000,000.00	87,954,020.00	45,980.00	99.95
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00	18,999,800.00	200.00	100.00
210602	Тавилга	19,000,000.00	18,999,900.00	100.00	100.00
210604	Урсгал засвар	50,000,000.00	49,954,320.00	45,680.00	99.91
2107	Томилолт, зочны зардал	18,458,000.00	18,449,700.00	8,300.00	99.96
210702	Дотоод албан томилолт	18,458,000.00	18,449,700.00	8,300.00	99.96
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	19,352,700.00	19,096,043.00	256,657.00	98.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,500,000.00	17,465,972.00	34,028.00	99.81
210803	Даатгалын үйлчилгээ	1,568,600.00	1,380,175.00	188,425.00	87.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,100.00	143,420.00	4,680.00	96.84

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	70,000.00	40,476.00	29,524.00	57.82
	ХӨТӨЛБӨР 70701	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80224	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	500,000.00	409,323.00	90,677.00	81.86
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	500,000.00	409,323.00	90,677.00	81.86
210	Бараа, үйлчилгээний зардал	500,000.00	409,323.00	90,677.00	81.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	500,000.00	409,323.00	90,677.00	81.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	409,323.00	90,677.00	81.86
	ХӨТӨЛБӨР 70701	-	-	-	-
	АРГА ХЭМЖЭЭ 80802	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343,946,800.00	254,445,309.98	89,501,490.02	73.98
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	343,946,800.00	254,445,309.98	89,501,490.02	73.98
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	343,946,800.00	254,445,309.98	89,501,490.02	73.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	343,946,800.00	254,445,309.98	89,501,490.02	73.98
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	235,286,000.00	160,285,653.00	75,000,347.00	68.12
213208	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	106,660,800.00	92,159,656.98	14,501,143.02	86.40
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,976,824,600.00	2,746,013,096.32	230,811,503.68	92.25
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,976,824,600.00	2,746,013,096.32	230,811,503.68	92.25
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,976,824,600.00	2,746,013,096.32	230,811,503.68	92.25
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	93.00	89.00	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	44.00	42.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	33.00	(2.00)	100.00
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.00	42.00	(2.00)	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч /ТЗ/	19.00	19.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	11.00	11.00	-	100.00
650010	Шүүгч, прокурор	14.00	12.00	(2.00)	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		124,816,136.40
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		124,816,136.40
210	Бараа, үйлчилгээний зардал		124,813,055.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		99,692,010.00
210102	Нэмэгдэл		99,692,010.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		12,461,500.66
210201	Тэтгэврийн даатгал		8,473,820.93
210202	Тэтгэмжийн даатгал		996,919.11
210203	ҮОМШӨ ний даатгал		498,460.05
210204	Ажилгүйдлийн даатгал		498,460.05
210205	Эрүүл мэндийн даатгал		1,993,840.52
2104	Хангамж, бараа материалын зардал		11,459,545.00
210401	Бичиг хэрэг		8,931,200.00
210402	Тээвэр (шатахуун)		528,345.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс		2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал		1,200,000.00
210702	Дотоод албан томилолт		1,200,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,080.74
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,080.74
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		3,080.74
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		124,816,136.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		124,816,136.40
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		124,816,136.40

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газар /цаашид Шүүхийн Тамгын газар гэх/ нь “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй хүргэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүхийн хүний нөөц, шүүхийн судалгаа, мэдээлэл, олон нийтийг мэдээллээр хангах зэрэг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах,
- Шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих,
- Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх,
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах,
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах,
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Монгол Улсын Их хурлын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 117 дугаар тогтоолоор бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосныг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Шүүхийн тухай хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,

- ШЕЗ-ийн 2024 оны 209 дүгээр тогтоолоор шүүхийн Тамгын газрын шүүхийн захиргааны ажилтны албан тушаалын цалингийн хэмжээг тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Шүүхийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ШЕЗ-ийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулсан төсвийн захирагчийн 2024 оны 1-9 сарын мэдээлэлд Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дах хэсэгт заасны дагуу явцын хяналтыг хэрэгжүүлж, ШЕЗ-ийн даргын 2024 оны 01/1858 дугаар албан бичгээр анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын дарга нарт 8 зөвлөмжийг хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШЕЗ-ийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар баталсан “ШЕЗ-ийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл мөрдөж, ШЕЗ-ийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 215 дугаар тушаалаар баталсан шинэчлэгдсэн бодлогын баримт бичгийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 178,496.6 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	14,040.0	131,490.0	117,450.0
Авлага	-	932.5	932.5
Бараа материал	20,097.3	25,849.0	5,751.7
Үндсэн хөрөнгө	1,120,096.1	1,174,458.6	54,362.5
Нийт хөрөнгө	1,154,233.5	1,332,730.0	178,496.6
Өр төлбөр	-	130,000.0	130,000.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,154,233.5	1,202,730.0	48,496.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,154,233.5	1,332,730.0	178,496.6

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 131,490.0 мянган төгрөг болж, 117,450.0 мянган төгрөгөөр өссөн нь “Шүүхийн тамгын газар барьцаа” дансанд 2 иргэнээс хуулийн дагуу төвлөрүүлсэн 130,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь голлон нөлөөлсөн,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,174,458.6 мянган төгрөг болж, 54,362.5 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2024 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 748 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан 116,387.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийн үнийг шинэчлэн тогтоож, 59,069.0 мянган төгрөгөөр данс бүртгэлд тусгасан, төсвийн хөрөнгөөр 41,758.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан, ШЕЗ-өөс 52,005.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлсэн авсан нь голлон нөлөөлсөн,
- Өр төлбөр дансанд 2 иргэнээс хуулийн дагуу төвлөрүүлсэн 130,000.0 мянган төгрөгийг тусгаснаас шалтгаалсан,
- Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ данс 48,496.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг *улсын төсвөөс* 2,821,517.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 477,249.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, эд хогшил, урсгал засварын зардлыг 622,745.6 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 31,273.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 40,347.6 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 30,590.0 мянган төгрөгөөр зэрэг нийт 762,684.3 мянган төгрөгөөр бууруулж, 2,536,082.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 28,125.0 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 41,000.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 16,500.0 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 341,946.8 мянган төгрөг зэргээр батлагдсан төсвийг нийт 440,741.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,976,824.6 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,976,824.6 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,907,324.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,746,013.1 мянган төгрөг буюу 92.3 хувьтай тайлагнагдсан байна. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны зардал: Шүүгчийн орон тоо дутуу ажилласнаас шалтгаалж, цалингийн зардлыг 139,588.8 мянган төгрөгөөр хэмнэсэн нь голлон нөлөөлсөн,
- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг:
 - ✓ Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын дагуу тэтгэвэрт гарсан шүүгчид **үндсэн цалингийн** дунджаас тооцож тэтгэмжийг олгосныг хүлээн зөвшөөрөөгүй, шүүхэд хандсаны дагуу шүүхийн шийдвэрийг үндэслэн зөрүү тэтгэмж 69,500.0 мянган төгрөгийг ШЕЗ-өөс тооцож олгосноос шалтгаалсан,
 - ✓ Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг гүйцэтгэлээр 10 албан хаагчид тооцож, олгосонтой холбоотойгоор 20,001.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/				
д/д		Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	70701	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах				
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,632,377.80	2,491,158.46	141,219.34	94.64
2	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	500.00	409.32	90.68	81.86
3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	343,946.80	254,445.32	89,501.48	73.98
		Дүн	2,976,824.60	2,746,013.10	230,811.50	92.25

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130005401 тоот дансанд аймгийн ТЕЗ-аас хуваарилсан орон нутгийн нэмэгдэл 112,156.6 мянган төгрөгийг төрийн захиргааны 18 албан хаагчийн нэмэгдэлд 99,693.8 мянган төгрөг, НДШ-д 12,462.7 мянган төгрөгийг тооцож олгосон байна.

Аймгийн ИТХ-аас Захиргааны хэргийн шүүхийн гэмт хэргийн сургалтын зардалд 7,931.2 мянган төгрөг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтын зардалд 4,728.3 мянган төгрөг нийт 12,659.5 мянган төгрөг төвлөрснөөс бичиг хэргийн зардалд 8,931.2 мянган төгрөг, тээвэр шатахуунд 528.3 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх зардалд /сургалтын цай, анонс/ 2,000.0 мянган төгрөг, томилолтын зардалд 1,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын даргаар батлуулж, тайлагнаж ажилласан бөгөөд тайлант онд шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авалт хийгдээгүй, тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,991,370.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 19,913.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй, халаалтын горимын өдөр, шөнийн градусыг тохируулснаар байгууллагын гэрэл, цахилгааны хэрэглээг хэмнэсэн зэргээр төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, баталсан төсвийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шүүхийн Тамгын газрын мэдээлбэл зохих 29 төрлийн 183 мэдээллээс 28 төрлийн 182 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, *дараа жилийн төсвийн төсөл* мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтуудыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны 173 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд **3,478.4** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага, ахмадын сангийн эх үүсвэрийг төсөвт тусган төлөвлөлгүйгээр жилийн эцэст цалингийн зардлаас **14,000.0** мянган төгрөгийг шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	3,478.4	1	3,478.4	100
Зөвлөмж	1	14,000.0	1	14,000.0	100
Нийт дүн	2	17,478.4	2	17,478.4	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **4,511.7** мянган төгрөгийн зөрчил илэрч, 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага:

1. Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр тайлант оны зардлаас **3,579.2** мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Тамгын газрын даргын 2023 оны үр дүнгийн урамшуулалд **1,579.2** мянган төгрөгийг тооцож олгосон,
- Тус газрын санхүүгийн тайланд бүртгэлтэй 4 айлын орон сууцны дулааны шугамын ажлын хөлс **2,000.0** мянган төгрөгийг олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”: 14.4.3 дахь “бүх өр төлбөр” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил гүйлгээг тухай бүр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Төлбөр, тооцоог урьдчилан хянаагүй, цалингийн тооцооллыг зөрүүтэй тооцоолсны улмаас НДШ-ийн **932.5** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, **авлага ба төлбөрийн тооцоог хянах**, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалин, нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тодорхой албан тушаалтны албан тушаалын тодорхойлолт, гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд заагдсан засвар, үйлчилгээ хийх, архивын баримт эмхэлж, үдэх, жижүүр хийх зэрэг ажлуудыг нийтээр амрах баярын өдрүүд, 7 хоногийн амралын өдрүүдэд хийж гүйцэтгэсэн гэх үндэслэлээр төрийн захиргааны болон үйлчилгээний ангиллын нийт албан хаагчдад сар бүр илүү цагийн нэмэгдлийг хавтгайруулан тооцож, олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4, 5 дугаар заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, эрхийн актуудыг хэрэгжүүлэн ажиллах.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5¹-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр тайлант оны зардлаас ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн.	1	3,579.2			1	3,579.2						
Авлага үүсгэсэн.	1	932.5			1	932.5						
Илүү цагийн нэмэгдлийг тооцож олгосон.	1	-						1	-			

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Дүн	3	4,511.7	2	4,511.7	1	-		
-----	---	---------	---	---------	---	---	--	--

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				/мянган төгрөгөөр/	
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил							
Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан.	1	-				1	-
Дүн	1	-				1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил							
Дүн							
Нийт дүн							